
ВИДЕО ШТОРК · 2024 оны 4-р сарын 23

2024 оны I улирал-МАНСУУРУУЛАХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТ 21.1 ХУВИАР ӨСЖЭЭ



Прокурорын байгууллагаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах 223 хэрэгт хяналт тавьж, 62 хүнд холбогдох, 34 хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж, шийдвэрлүүллээ.

Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон 125 хүний 2.4 хувь нь 17 хүртэл, 4.8 хувь нь 45-аас дээш, 25.6 хувь нь 31-44 настай байгаа бол дийлэнх буюу 67.2 хувь нь 18-30 насны хүмүүс байна.

Хүйсийн хувьд 80.8 хувь нь эрэгтэй, 67.2 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй иргэд байна.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн 88.8 хувь нь Нийслэлд, 11.2 хувь нь Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Дорноговь, Архангай, Өмнөговь, Хэнтий аймагт бүртгэгджээ.

Энэ төрлийн хэрэг 2023 оны мөн үетэй харьцуулахад 21.1 хувиар өссөн байна.

Видео: https://www.youtube.com/watch?v=1tPWT_mClco

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1148